



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-03-11 № 1/111
танай 2024-02-15-ны № 04 -т

МЯНГАН-УГАЛЗАТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.ОТГОНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБООС 2706.7-д тодорхойлсноор Мянган-Угалзат ОНӨААТҮГ нь 382,974.7 мянган төгрөгийн балансын үнэтэй 163,773.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Аудитын гол асуудал

АДБООС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

АДБООС 2706.10-д зааснаар Мянган-Угалзат ОНӨААТҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь зорилтот түвшинг баталж өгөөгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

1. ХӨРӨНГӨ	2022.12.31	2023.12.31
1.1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	47,950.96	185,803.49
Дансны авлага /ТӨҮГ/	21,583,502.00	21,583,502.00
Бусад авлага /байгууллагаас авах авлага/	234,848.00	234,848.00
Бараа материал	72,696,439.6	28,354,600.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,562,740.59	50,358,753.49
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	373,579,431.74	74,193,439.35
Биет бус хөрөнгө	200,192,974.45	200,000,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	573,772,406.19	274,193,439.35
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	668,335,146.78	324,552,192.84
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
2.1. Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг		
Цалингийн өглөг	5,795,200.00	5,513,334.88
Татварын өр	47,307,910.28	59,339,431.20
НДШ-ийн өглөг	18,805,870.32	31,659,370.17
Бусад БХӨТ	143,521,031.00	109,261,958.41
Богино хугацаат өр төлбөрийн дүн	215,430,011.60	205,774,094.66
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	215,430,011.60	205,774,094.66
2.3. Эздийн өмч		
Өмч: - төрийн	559,038,740.00	559,038,740.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	308,206,206.00	257,658,892.07
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-414,339,810.82	(697,919,533.89)
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	452,905,135.18	118,778,098.18
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	668,335,146.78	324,552,192.84

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого	145,908,954.50	126,912,764.85
Борлуулалтын өртөг	139,001,119.86	125,579,154.75
Нийт ашиг (алдагдал)	6,907,834.64	1,333,610.10
Бусад зардал	92,544,101.15	80,377,272.44
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(85,636,266.51)	(79,043,662.34)
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг (алдагдал)	(85,636,266.51)	(79,043,662.34)
Зогсоосон үйл ажиллагааны ТД ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(85,636,266.51)	(79,043,662.34)
Орлогын нийт дүн	(85,636,266.51)	(79,043,662.34)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	559,038,740.00	308,206,206.00	(414,339,810.82)	452,905,135.18
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(204,536,060.73)	(204,536,060.73)
Залруулсан үлдэгдэл	559,038,740.00	308,206,206.00	(618,875,871.55)	248,369,074.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(79,043,662.34)	(79,043,662.34)
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт		(50,547,313.93)		(50,547,313.93)
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	559,038,740.00	257,658,892.07	(697,919,533.89)	118,778,098.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	224,114,435.97	139,604,041.34
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	224,114,435.97	139,604,041.34
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		
<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	224,132,262.23	139,466,188.81
Ажиллагчдад төлсөн	74,807,948.21	77,031,312.49
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,150,000.00	5,489,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	39,833,303.00	2,609,909.50
Ашиглалтын зардалд төлсөн	6,547,750.00	23,838,873.30
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,888,900.00	7,950,547.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	31,061,375.12	1,622,790.91
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	5,842,985.90	20,923,755.61
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,826.26)	137,852.53
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(17,826.26)	137,852.53
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,777.22	47,950.96
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,950.96	185,803.49

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 274,193.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 274,193.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 274,193.4 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын өмчлөлд байсан Нэвт рашаан сувиллын газрыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор бусдад 10 жилийн түрээсээр эзэмшүүлэх гэрээг байгуулан бусад байгууллагад өгөхдөө өр төлбөр болон үндсэн хөрөнгийг тухайн байгууллагад нь шилжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; “ гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Нэвт рашаан сувиллын хөрөнгө, өр төлбөрийн асуудлыг хэлэлцүүлэн холбогдох байгууллагад нь шилжүүлэн үл хөдлөх хөрөнгийн татварын ачааллыг бууруулан ажиллах

3.1.2. Өглөг данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын хуримтлагдсан өр төлбөр нь материаллаг дүнтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Мянган-Угалзат ОНӨААТҮГ	Түрээсийн гэрээгээр эрх нь шилжсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад нь шилжүүлэн өгөх	1	274,193.4					1	274,193.4		
ДҮН		1	274,193.4			-	-	1	274,193.4		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Мянган-Угалзат ОНӨААТҮГ	Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллаагүй	1	0					1	0
ДҮН		1	0					1	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ТБОНӨААТҮГ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			